



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН - 2023

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХҮН АМЫН САН



## АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ .....	1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ .....	2
БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЭРХ	3
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ .....	6
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ .....	9
ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ .....	10
ӨМНӨД - ӨМНӨДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА .....	13
ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАЛЦАА .....	14
ХАНДИВЛАГЧ БОЛОН ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД .....	15



## МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт хамтрагч байгууллага, хамт олон, дэмжигч та бүхэндээ Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан 2023 оны үйл ажиллагааны тайлангаа толилуулахын зэрэгцээ, Луу жилдээ нялхас хүүхэд, тэдний гэр бүл түвшин сайхан, охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тэмцэл хүчтэй, залуучуудын хөгжлийг дэмжих сайн үйлс бүхэн дэлгэрэхийг хүсэн ерөөе.

Өнгөрч буй 2023 онд өрнөсөн хамтын ажиллагааны үр дүнд НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх жендэрийн тэгш байдал, залуучуудын хөгжил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх гол зорилго бүхий 7 дахь хөтөлбөрийн хэрэгжилтийг амжилттай эхлүүлснийг дуулгахад таатай байна.

Энэхүү хамтын хүчин чармайлтын хүрээнд НҮБ-ын Хүн амын сан нь Монгол Улсын Засгийн газар, иргэд олон нийт, иргэний нийгэм, хувийн хэвшил төдийгүй НҮБ-ын агентлагууд, олон улсын болон хандивлагч байгууллагуудтай амжилттай хамтран ажиллалаа. Бид хамтдаа алслагдсан 22 сум, өрхийн эрүүл мэндийн төвд орчин үеийн теле-уулзалтын техник технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд зайнаас суралцах, харилцан зөвлөх боломжийг бүрдүүллээ. Мөн 234 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц сургалтанд хамрагдаж, шинэ мэдлэг, чадварыг эзэмшин, үр шимийг нь хэдийн хүртээд байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-тэй тэмцэх тэмцэлд илүү олон хүмүүс нэгдэн, ихээхэн ахиц дэвшил гаргаж, мэдээлэл сургалтаар дамжуулан 4000 орчим эрэгтэйчүүд, хөвгүүд ЖСХ-ийн талаар ойлголт, мэдлэг мэдээллээ дээшлүүллээ. Түүнчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг амжилттай өрнүүлсний дүнд нийт 10 аймгийн Залуучуудын хөгжлийн төв дижитал хаб-тай болж, орон нутагт залуучуудын мэдлэг, чадвараа хөгжүүлэх, чадавхжих чухал орчин болсонд баяртай байна.

Хүн ам, хөгжлийн олон улсын бага хурлын 30 жилийн ой 2024 онд тохиох бөгөөд Монгол Улс 1994 онд болсон бага хурлаар “Эмэгтэйчүүд хэзээ, хэдэн удаа жирэмсэн болох эсэхээ өөрсдөө шийдэх эрхтэй” гэдгийг баталсан 179 орны нэг болсон. Түүнээс хойш Монгол Улсын Засгийн газар охид, эмэгтэйчүүдийн сонголт, эрхийг баталгаажуулсан олон чухал үүрэг амлалтыг хэрэгжүүлсээр байна. Гэсэн ч сэргийлж болох эхийн эндэгдлийг тэглэх, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг тэглэх, охид эмэгтэйчүүдийн эсрэг аливаа хүчирхийллийг тэглэх зорилгын хүрээнд хийж, хэрэгжүүлэх шаардлагатай олон ажил байна. Эдгээр гурван өөрчлөлтийг бодит үр дүн болгоход хамтын ажиллагаа, хүчин чармайлтаа өрнүүлэн бидэнтэй хамтран ажиллаж буй ТА БҮХЭНД ДАХИН ТАЛАРХЛАА ИЛЭРХИЙЛЬЕ!

**Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн,  
доктор Халид Шарифи**

# Үйл ажиллагааны тойм 2023



Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх дэлхий нийтийн санаачилгад Монгол Улс нэгдлээ.



Алслагдсан 22 сум, өрхийн эрүүл мэндийн төвд теле-уулзалтын техник технологийг нэвтрүүлэн, зайнаас суралцах, зөвлөх боломж бүрдүүлээ.



Үндэсний хэмжээнд эх, нярайн ба бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц сургалтад 234 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч хамрагдав.



Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд багтлаа.



4000 орчим эрэгтэйчүүд, хөвгүүд жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн талаар ойлголт, мэдлэгээ дээшлүүллээ.



ЖСХ-ээс сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чадавх бэхжүүлэх сургалтад 2,500 гаруй үйлчилгээ үзүүлэгч хамрагдлаа.



ЖСХ-ийн 2017 оны судалгаагаар тогтоогдсон хүчирхийлэлийн эрсдэл, хамгаалах хүчин зүйлд нарийвчилсан дүн шинжилгээ хийлээ.



Эрэгтэйчүүдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв байгуулж, нийт 200 гаруй иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өглөө.



Бэлгийн цогц боловсролын талаар 60 шинэ “AMAZE” видео бэлтгэн [www.medle.mn](http://www.medle.mn)-д байрлуулснаар өсвөр үеийнхэн үнэн зөв, бодит мэдээлэл авах боломж бүрдэв.



Улсын хэмжээнд 31 сургагч багш бэлгийн цогц боловсролыг дээшлүүлэх сургалтыг 231 багшид хүргэв.



Төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг амжилттай өрнүүлсний дүнд 10 аймгийн Залуучуудын хөгжлийн төв дижитал хаб-тай боллоо.



## БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЭРХ

Ээжүүдийг эсэн мэнд амаржих нөхцлөөр хангах нь хүний эрхийн зайлшгүй шаардлага бөгөөд энэ нь НҮБ-ын Хүн амын сангийн гол чиг үүрэг юм. Хүн бүр эрхээ эдэлж, сонголт хийх нөхцөлийг дэмжих, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Засгийн газар, эрүүл мэнд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна.



# БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЭРХ

## 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх дэлхий нийтийн санаачилгад Монгол Улс нэгдлээ. Энэхүү санаачилгын хүрээнд туршилтын гурван хороо байгуулагдаж, хороодын гишүүд Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээний аргачлалд суралцлаа.
- Түүнчлэн учир шалтгааны дүн шинжилгээний аргыг ашиглан 2023 оны эхийн болон перинатал эндэгдлийн тохиолдлуудад 7 удаагийн хяналт үнэлгээ хийлээ. Үнэлгээний үр дүнгээр чанарыг сайжруулахад “зэмлэлгүй соёл”-ыг нэвтрүүлж, болзошгүй эндэгдлээс сэргийлэх SMART хариу арга хэмжээг боловсруулав.
- ЖСХ-ийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зорилгоор салбарын бэлэн байдлын үнэлгээ хийж гүйцэтгэлээ.
- Гэр бүл төлөвлөлтөд хөрөнгө оруулахын эдийн засгийн ашгийн өртөг зардлын тооцоонд шаардлагатай мэдээ мэдээллийг Нийгмийн үзүүлэлтийн үндэсний түүвэр судалгааны асуумжид амжилттай тусгав.
- АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, ЖАЙКА-тай хамтарсан нөлөөллийн арга хэмжээний үр дүнд эх барихуйн шилдэг туршлагыг нэвтрүүлснээр Эрүүл мэндийн яам (ЭМЯ) эх баригчийн мэргэжлийн цогц чадамжийг баталлаа.



# БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЭРХ

## 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Люксембургийн Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-д 4 сартайгаас 7 насны долоон хүүхдийн амь насыг аврах хагалгааг амжилттай гүйцэтгэлээ.
- Нийслэлийн болон 10 аймгийн алслагдсан 22 эрүүл мэндийн төвд теле-уулзалтын иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулж, зайнаас харилцан зөвлөх, суралцах боломжийг бүрдүүлэв.
- ЭХЭМҮТ жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хангамжийн удирдлагын цахим мэдээллийн тогтолцоотой болж, тоо мэдээнд суурилан шийдвэр гаргах боломжтой боллоо. Түүнчлэн ЭМЯ-наас жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хангамжийн удирдлагын журмыг шинэчлэн батлав.
- Монгол Улсын Дархлаажуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хүний папиллома вирус (HPV)-ийн эсрэг вакцин нь заавал хийх дархлаажуулалтын жагсаалтад орлоо.
- Нийт 234 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ, эх барихын яаралтай тусламж үйлчилгээ, гэр бүл төлөвлөлтийн програм хангамжийн ашиглалт, бэлгийн ба дотно хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн үед үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх сургалтад хамрагдлаа.



# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Жендэрийн эрх тэгш байдал нь аливаа хөгжлийг урагшлуулж, ядуурлыг бууруулах суурь нөхцөл билээ. НҮБ-ын Хүн амын сан охид, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, бодлогын болон хууль эрхзүйн шинэчлэлийг дэмжин, жендэрийн мэдрэмжтэй тоон мэдээлэл, охид эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдний амьдралдаа хийх сонголтыг хүндэтгэх санал санаачлагуудыг дэмжин ажиллаж байна.



## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

### 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Төрөл бүрийн ажил мэргэжил бүхий 4000 орчим эрэгтэйчүүд, хөвгүүд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар ойлголт, мэдлэгээ дээшлүүлэв.
- ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор үндэсний, орон нутгийн түвшний 2,500 гаруй үйлчилгээ үзүүлэгчид чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдлаа.
- Эрэгтэйчүүдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт 2023 оны 5 дугаар сард байгуулагдлаа. Тус төв нь хувь хүний сэтгэл зүй, хосуудын харилцаа зэрэг сэдвээр зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг ба нийт 22 хос, 200 гаруй хувь хүнд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөөг тусгайлан боловсруулсан аргачлалыг дагуу өгөөд байна.
- Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Засгийн газрын тайлан боловсруулахад дэмжлэг үзүүлэв. Тайлангийн үр дүнг УИХ-аар хэлэлцэн, хуулийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой үйл ажиллагааны хөтөлбөрийг бүх яамдад танилцуулав.
- Жендэрийн эрх тэгш байдлын талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн хортой хэм хэмжээг арилгах зорилгоор 3 сарын 1-нээс 4 сарын 1-ний хооронд “Харилцан хүндэтгэе” аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд хийгдсэн медиа материалууд нийгмийн сүлжээ болон уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин нийт 1.4 сая хүнд хүрлээ.



# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

## 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэв. Үнэлгээний үр дүн, зөвлөмжийг холбогдох талуудад танилцуулан, санал зөвлөмжийг тусган “ЖСХ-тэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” үндэсний чуулганы үеэр танилцуулав.
- ЖСХ-ийн 2017 оны судалгаагаар тогтоогдсон хүчирхийллийн эрсдэл, хамгаалах хүчин зүйлд нарийвчилсан дүн шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнг баталгаажуулах, бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор оролцогч талуудтай хэлэлцэж, шийдвэр гаргагчдад танилцууллаа.
- Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны үйлчилгээний чанар сайжирсныг тус төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа харууллаа. Тодруулбал, судалгаанд хамрагдагсдын 52.7% нь хүссэн үйлчилгээ авч чадсан гэж 2019 онд хариулж байсан бол энэ тоо 2023 онд 95% болж өссөн байна.
- Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар 2023 онд нийт 4,037 хүн үйлчлүүлснээс 729 нь насанд хүрэгчид, 3308 хүүхэд буюу насанд хүрээгүй иргэд байлаа.





## ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯН

НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын агентлагууд, хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ЖСХ-тэй тэмцэх 16 хоногийн аяныг “Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хөрөнгө оруулъя” дэлхий нийтийн сэдэв дор [“ХҮНДЛЭЛ хамгийн тод гэрэл”](#) уриан дор өрнүүлэн, амжилттай зохион байгууллаа.

Аян 11 дүгээр сарын 25-ны өдөр Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан хэвлэлийн бага хурлаар албан ёсоор эхэлж, 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 16 хоногийн турш үргэлжилсэн юм. Энэ жилийн аяны гол зорилтот бүлэг нь ирээдүйн өөрчлөлтийг түүчээчлэгч залуус тэр дундаа их, дээд сургуулийн оюутнууд байлаа.

### Бүх түвшний оролцоо:

УИХ, бүх аймаг, дүүрэг, салбар яам, агентлаг, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг нийт 300 орчим байгууллага ЖСХ-ийг таслан зогсоох амлалтаа батлан, 16 хоногийн аянд нэгдсэн юм.

Аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, хэлэлцүүлэг, медиа бүтээлүүд нийгмийн сүлжээ болон уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан давтагдсан тоогоор 8.3 сая хүнд хүрлээ.

## ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

Өнөөдөр 1.8 тэрбум өсвөр үе, залуучууд дэлхийн хүн амын ¼-ийг бүрдүүлж байна. Тэд нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлж, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлтэй нүүр тулж, дэлхийн ирээдүйн суурийг тавьж байна. НҮБ-ын Хүн амын сан залуучуудын оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх, хүний эрх, хөгжлийн асуудлуудыг урагшлуулахад залуучуудын чадавхыг бэхжүүлэн, хамтран ажиллаж байна.





## ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

### 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Хүчирхийлэлгүй сургууль” бодлого НҮБ-ын Хүн амын сангийн техникийн дэмжлэгтэйгээр батлагдаж, хүртээмжтэй боловсрол, чадавх бэхжүүлэх ажлыг өрнүүлэн, үр дүнтэй бодлогын хэрэгжилтийг хангаж байна.
- Бэлгийн цогц боловсролын 60 шинэ “AMAZE” видео болон багш нарт зориулсан гарын авлагыг Монгол хэлнээ хөрвүүлэн, бэлтгэж, [www.medle.mn](http://www.medle.mn) -д байрлууллаа. Ингэснээр өсвөр үе, залуучууд шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв мэдээллийг цахимаар авах боломжтой боллоо.
- Үндэсний хэмжээнд 31 сургагч багштай хамтран бэлгийн боловсролын цогц, чанартай сургалтыг зохион байгуулж, нийт 231 багш хамрагдлаа. Цахим сургалт 600 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчдэд хүрсэн нь бэлгийн боловсролын сургалтын хөтөлбөр, чанар сайжрахад чухал нөлөө үзүүллээ.
- Бэлгийн цогц боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-ийн сурагчид тэр дундаа тусгай хэрэгцээт сурагчдад зориулсан хүртээмжтэй заах аргазүйг сургалтын хөтөлбөрт нэгдсэн удирдамж боловсрууллаа.
- Сурган хүмүүжүүлэгчдийн сургалтын материалын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд амьдрах ухааны суралцах төвүүдийн багш нарт зориулан амьдрах ухааны цахим модулийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүллээ.

## ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

### 2023 ОНЫ ГОЛЛОХ ҮР ДҮН:

- Эрүүл мэнд, боловсролын салбарын уялдаа холбоог нэмэгдүүлэх ерөнхий зорилгын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ЕБС-ийн Эрүүл мэндийн хөтөлбөрийг боловсруулах зорилго бүхий үнэлгээ зохион байгууллаа.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг амжилттай өрнүүлсний үр дүнд нийт 10 аймгийн Залуучуудын хөгжлийн төвд Дижитал хаб байгуулагдлаа.
- "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангахад бодлогын хэлэлцүүлэг өрнүүлж, олон талт салбарын оролцоог дэмжих зорилгоор Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганыг дэмжин ажиллалаа. Чуулганд нийт 680 орчим залуусын төлөөлөл оролцож, 4500 хүнд цахимаар хүрсэн юм.
- Алслагдсан аймаг орон нутаг тухайлбал Баян-Өлгий аймагт залуучуудын бэлгийн цогц боловсролыг дээшлүүлэх зорилгоор радио нэвтрүүлэг бэлтгэн хүргэлээ.
- Өвөрхангай аймгийн гурван суманд өсвөр үе, залуучуудын бэлгийн цогц боловсролыг нэмэгдүүлэх зорилго бүхий амьдрах ухааны боловсролын танхим нээгдлээ.



# ӨМНӨД - ӨМНӨДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Мавританын Засгийн газрын төлөөлөгчид эх, нялхсын төрөлтийн хүндрэлд телемедицинийг амжилттай ашиглаж буй Монгол Улсын сайн туршлагыг судаллаа. Энэ нь Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд Мавритан, Монгол Улс хоорондын эх, нялхсын эндэгдэл, өвчлөлийг бууруулах чиглэлд хамтран ажиллах анхны алхам болсон юм.



Өмнөд - Өмнөдийн хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд НҮБ-ын Хүн амын сан хил дамнасан залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү стратегийн ач холбогдол бүхий “Уур амьсгалын өөрчлөлт ба Залуучууд” олон улсын чуулган нь оролцогчдод уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө, шийдлүүдийг чөлөөтэй хэлэлцэх, санал солилцох боломжоор хангасан юм. Мөн оролцогчид мэдлэг, чадавхаа дээшлүүлснээс гадна БНХАУ, Монгол Улсын залуучуудын хооронд хөгжлийн харилцан яриа, хэлэлцүүлэг өрнөсөн юм.



Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын төлөөлөгчид манай улсын ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний стратеги, тэр дундаа хохирогчдыг хамгаалах механизмыг нэвтрүүлсэн сайн туршлагыг судлалаа. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улс хүчирхийллийг даван туулагчдын аюулгүй байдал, шударга ёсыг хангах жишиг загварыг бий болгоод байна.



## ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАЛЦАА

Зуд болон үерийн гамшигт өртсөн охид, эмэгтэйчүүдэд 1,760 ариун цэвэр, эрүүл ахуйн багц өгөв.

Жендэрийн эрх тэгш байдал, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд Монгол Улсын таван салбарт гамшгийн бэлэн байдал, эрсдлийг бууруулах үнэлгээг CADRI-тай хамтран хэрэгжүүллээ.

Онцгой байдлын ерөнхий газартай хамтран онцгой байдлын үед бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс бэлэн байдлын үнэлгээг хийв.



# ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТРАН АЖИЛЛАСАН ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД, ТҮНШҮҮДДЭЭ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ!





НҮБ-ын Хүн Амын Сан

*Жирэмслэлт бүр хүссэн, төрөлт  
бүр эсэн мэнд, залуу хүн бүхэн  
нөөц бололцоогоо бүрэн дайчилж,  
хөгжлийн өндөрлөгт хүрэх  
нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө!*

Холбоо барих:

